

МОНГОЛЬСКАЯ НАДПИСЬ

НА ПАМЯТНИКЪ

КНЯЗЯ ИСУНКЪ,

племянника Чингисъ-Хана,

ОВЪЯСНЕННАЯ

ДОРДЖИ БАНЗАРОВЫМЪ,

членомъ-корреспондентомъ Императорскаго Археологическаго Общества,

СЪ ПРЕДИСЛОВІЕМЪ

П. С. Савельева,

Члена-основателя и Секретаря того же Общества,

и съ приложеніемъ снимка съ надписи.



(Отпечатано изъ III тома Записокъ Общества.)



САНКТПЕТЕРБУРГЪ.

ВЪ ТИПОГРАФИИ ЭКСПЕДИЦИИ ЗАГОТОВЛЕНІЯ ГОСУДАРСТВ. БУМАГЪ.

1851.

Д.БАНЗАРОВ. "ЧИНГИС ХААНЫ АЧ ДҮҮ ЕСҮНГЭ ВАНГИЙН ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ МОНГОЛ БИЧЭЭСИЙН ТАЙЛБАР" ӨГҮҮЛЛИЙН ӨМНӨХ ҮГ*

Энд анх удаа толилуулж буй бүрэн хэмжээний орчуулгатай бичээс Чингис хааны нэрээр алдаршсан нь энэ хааны нэрийг дээд мөрөөс бичсэнтэй хобоотой бөгөөд уг нэрийг хөшөөг олж нээсэн цагаас Сибирийн хэлмэрчид хүртэл төвөггүй уншиж байсных билээ. Шинжлэх ухааны хувьд энэхүү бичээс нь монгол бичгийн хамгийн эртний дурсгал гэдгээрээ ач холбогдолтой юм. Парист хадгалагдаж буй Аргун болон Өлзийт хааны Францын ван IV Филиппт илгээсэн захидлууд энэ бичгээс хэдэн арван жилийн дараа үйлдэгдсэн ба гагцхүү Хүлэгү хааны зоосон дээрх цөөн хэдэн монгол үг л манай дурсгалтай нэг үеийнх байх.

Өвөг дээдсийнхээ алдар цуугаа мандуулсан эрин үе болох XIII зууны дунд үеийн эдүгээ мэдэгдэж буй хамгийн эртний дурсгалыг тайлбарлах нэр хүндтэй үүрэг н. Банзаровт оногджээ. Банзаров Петербургт байхдаа 1848 онд бичээсийг тайлж унших оролдлого хийсэн боловч зарим балархай үг түүнийг гацааж байлаа. Нэвт гэрэлтдэг цаасан дээр уул чулуунаас бичээсийг буулгаж авсан тэрбээр албан ажлаар Сибирьт томилогдон явахдаа ч судалгаагаа орхиогүй юм. Ингэсээр 1850 онд Эрхүүд байхдаа тэрбээр бичээсийн эдүгээ хүртэл таавар байсан бүх үгийг бүрэн гүйцэд тайлжээ. Түүний судалгааг уншигчиддаа ийнхүү толилуулж байна.

Манай монгол судлаач эрдэмтэн Эрхүүд судалгаагаа бичиж байхад нь энэхүү дурсгалыг олсон түүх, бичээсийг өмнө нь тайлбарлах гэсэн оролдлогуудын талаарх шаардлагатай ном зохиол гар дор нь байгаагүй учир энэ тухай тэмдэглээгүй орхисон байна. Иймд өгүүллийг иж бүрэн болгох зорилгоор бид энэхүү дурсгалын тухай түүхэн тоймыг өмнөтгөл болгон оруулахаар шийдлээ. Энэхүү дурсгалын талаар анхны бөгөөд харьцангуй тодорхой мэдээг н. Спасский 1818 онд нийтэлсэн юм¹. “Аргун мөрөнд зүүн талаас нь цутгадаг Өрлөнгө голын хойд талаар сунасан битүү ойтой боржин уулс нурууд хагас өдөрчийн газар үргэлжилсээр Хятадын нутагт орж өргөн уудам хээр талаар солигдоно. Эдгээр нуруудаас эх авсан олон булаг гол руу урсах авч замдаа хад чулууны дунд шурган шингэнэ. Олон булгийн нэг Хархираа ба Бага Хөндий булгийн эргээс байшин барилгийн туурь олджээ. Эхний газар буюу Хархираа булгийн эрэг дэх туурь одоо хэр нь судлагдаагүй ажээ. Надад ирүүлсэн дэвсгэр зургаас² харахад хоёр туурь хоорондоо 90 сажин зайтай байна. Шороон далангууд буюу овоолсон шорооны зарим нь тал тал тийш чиглэсэн байгаа нь хачирхалтай. Зарим нь хэрмийн суурь мэт тэгш дөрвөлжин хэлбэртэй ч байна. Эдгээр дурсгалаас 5 мод газрын тэртээ булгийн эх орчимд хэдэн модон булш бий. Булшны тэнд тодорхой сийлсэн дорно дахины үсэгтэй бичээс бүхий том боржин чулуу анхаарлыг зүй ёсоор татаж байна хэмээн зарим хүмүүс батлан хэлдэг. Гэвч энэхүү чулууг Хөндий дэх эртний туурийг ухахад олдсон дурсгалын нэг мөн гэж олонх нь нотлон хэлж байгаа юм. Ноён Спасскийн тэмдэглэснээр энэ чулууг Нэрчүүгийн үйлдвэрт хүргэж тэнд бусад эртний дурсгалын хамт хадгалж

* Орос хэлнээс орчуулсан доктор Ц.Энхчимэг.

¹ *Сибирский вестник*. Ч. IV, отд. II. 1818, стр.116-124

² Энэ дэвсгэр зургийг *Сибирский вестник* сэтгүүлд XIX хавсралт болгон хэвлэсэн. .

байжээ. Мөн н. Шмидтийн мэдээлснээр н. Спасский хөөцөлдөж байж уг дурсгалыг 1829 онд С.-Петербург хот руу явуулах шийдвэр гаргуулсан байна³. Дурсгалыг олсон Хөндий дэх туурийг тодорхойлон бичихдээ н. Шмидт анх энэ дурсгал олдсон Хархираагийн дурсгалуудын талаар огт дурдаагүй байна. 1832 онд энэ дурсгалыг Петербургт аваачиж Сангийн яаманд хадгалж байгаад 1839 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэнд тавьж олон нийтэд үзүүлжээ. Үзэсгэлэн хаагдахад уг дурсгалыг Шинжлэх Ухааны Академид шилжүүлэн өгч улмаар Академийн шийдвэрээр энэхүү түүхэн дурсгалыг Азийн музейн хаалганы өмнө шатан дээр байрлуулсан байна.

Уг боржин хавтан дурсгалын урт нь 2 аршин 13 цун, өргөн нь $14\frac{3}{4}$ цун, зузаан нь 5 цун. Чулуун хөшөө бараг голоороо шахуу хугарсан байна. Нэрчүүгийн үйлдвэр лүү тээвэрлэхэд гэмтсэн байж болзошгүй. Банзаровын өгүүллээс харахад үсэг дайрсан энэхүү гэмтэл нь бичээсийг тайлж уншихад төдийлэн төвөг болохгүй аж.

Хөшөөний бичээсийг тайлж унших анхны оролдлогыг Сибирийн хэлмэрч лам нар хийсэн ба зарим үгийг төвөггүй уншжээ. Үүнд:

*Чингис хаан ... даган .. хамаг монгол улсын ардыг*⁴

Хиагтын монгол хэлний багш н. Ванчиков нэмж хэдэн үг тайлж уншсан боловч эртний үл мэдэх үгсээ тааж орчуулжээ. Тэрбээр бичээсийн орчуулгыг дараах байдлаар хийжээ.

*Чингис хаан сартуул ардыг эзлэн аваад хамаг монгол ардыг эртний ордод нэгтгэж Ононгоор байгсад явуулсан гурван зуун гучин тавд эзлэгдэв*⁵.

Хөшөөг С.-Петербург хотод зөөж аваахад бичээсийн орчуулгыг шинээр хийж Шинжлэх Ухааны академийн эрдэм шинжилгээний цувралд нийтэлсэн байна. Тэрхүү орчуулга дараах байдалтай.

*Чингис хаанаас сартуул ардыг дайлан бууж хамаг монгол улсын эрт цагийн хуучин самууныг эцэс болгож гурван зуун гучин таван Elje (ад чөтгөр) ... хөөгдсөний тэмдэгт*⁶.

Эцэст нь н.Банзаров өмнөх орчуулагчдад төвөгтэй байсан үгсийг бүрэн тайлбарлаж өөрийн орчуулгаа толилуулав. Тус орчуулгыг Хиагтын багш ба Петербургийн академичийн хийсэн өмнөх хоёр орчуулгатай харьцуулан үзэхэд энэ хоёр орчуулга үнэнээс хол агаад агуу их Чингис хаан 335 ад чөтгөрт зориулан гэрэлт хөшөө босгосон гэж эрүүл ухаанаар бодоход байж боломгүй Петербургийн орчуулгаас харин Хиагтын орчуулга нь арай дээр гэдгийг уншигч төвөггүй олж харна. Хэрэв н. Шмидт өөрийн хийсэн орчуулгыг “логик уялдаа холбоотой” гээд харин Ванчиковын орчуулгыг “утгагүй”, “тэнэг хүний хоосон яриа” гэж бичээгүйсэн⁷ бол бид энэ талаар огт дурдахгүй байх байлаа. Хоёр орчуулгыг ингэж харьцуулах нь шинжлэх ухааны бүтээлийн нэр хүндийн талаарх маргаан болон хувирч байна. Тухайлбал н. Ванчиковын орчуулгыг олж үзсэн сарептын хэлмэрч асан өөрийгөө “Монголын талаар” онц эрхтэн хэмээн үзэж хүндэт эцэг ламтан Ианкинфийг орчуулсан гэж ташааран түүнд зохисгүй зүйлийг хэвлэлээр дайсан юм. Эцэг ламтан Иакинф эрдэмтэн хүний эрхэм чанар агаад төлөв даруу байдлаар хариу барьжээ. Үзэсгэлэн зохион байгуулах хорооны дарга хүртэл манай алдарт нанхиад судлаач хөшөөний бичээсийн шинэ орчуулгад огт хамаагүй болохыг батлан гэрчилжээ⁸.

³ Memoires de l'Acad. Imper. des sciences de St. Petersb. (1833). VI serie. T-II. I.-J.Schmidt's Bericht uber eine Imschrift aus der altesten Zeit der Mongolen-Herrschaft. S.249

⁴ Сибирский вестник, loc. cit., стр.123.

⁵ Энэхүү орчуулгыг уг гэрэлт хөшөөг 1839 онд үзэсгэлэнд тавихад дагалдуулсан юм.

⁶ Memoires de l'Acad., loc. cit., стр.252. Герман хэлээрх орчуулга нь дараах байдалтай болно. Үүнд: Von Tschinggis-Chan, als er nach Unterwerfung des Sartagolschen Volkes zurückgekehrt war und aller mongolischen Volksstämme von früheren Zeiten herrschenden Groll ein vollständiges Ende gemacht hatte, den sämtlichen drei hundert fünf und dreissig Eljê (Dämonen) des als... Bannung.

⁷ Я.Шмидт. О новом переводе монг. надписи на известном памятнике Чингис-хана. С.-Петебург. вед. 1839 г. №224.

⁸ н. Шмидт, Иакинф ламтан болон н. Комаров нарын 3 өгүүлэл бүгд Отеч. зап. 1839 (Т-VI, Смесь, стр.27-33)-д хамт дахин хэвлэгджээ.

Төгсгөлд нь, бичээсийн хуулбар зураг ялангуяа энэхүү өгүүлэлд хаваргасан гэрэл зургийн талаар хэдэн үг хэлэх хэрэгтэй.

н. Спасский хөшөөний гар зургийг $\frac{1}{8}$ хүртэл жижигрүүлэн анх хэвлэжээ. Мэдээж монгол хэл мэдэхгүй хүн хийсэн тул бичиг ч буруу болжээ.

н. Шмидт бас жижигрүүлсэн гэрэл зургийн хувийг өгүүлэлдээ хавсарган хэвлэсэн билээ⁹. Гэвч энэ хуулбар мөн л хангалтгүй болсон нь бичээсийн гэрэл зургийг авсан бус харин хуулбарлахдаа бичлэг зурлагын байдлыг хадгалаагүй ба эх бичигт балархай байгаа үсгүүдийг дураараа нөхөж бичсэнтэй холбоотой юм.

н. Банзаров хөшөөний бичээсийг бүхэлд нь багтаасан гэрэл зургийг өгүүлэлдээ хавсаргахыг хүссэн юм. Эртний бичиг зүйн шинж тэмдгийг мэдэх хүнд болоод хуулж буй бичээсийн хэлийг үл мэдэх чулуун барчийн хийсэн жижигрүүлсэн зураг дахь бичгийн онцлогийг авч үлдэх боломжгүйг мэдэх хүнд энэ бол зүй ёсны хүсэл билээ. Хоёр аршин урттай, нэг аршин өргөнтэй чулуун барын зургийг ийм цаасны $\frac{1}{8}$ хэмжээтэй хэвлэж өгүүлэлд хавсаргах нь хэцүү бөгөөд боломжгүй юм. Гэтэл өгүүлэлд дэвшүүлсэн бичээсийн тайлбарыг нотлон харуулахын тулд үнэн зөв зургийг хэвлүүлэх шаардлага тулгарч байлаа. Яах вэ? XIII зууны үеийн монгол бичгийг үнэн зөвөөр жижигрүүлж буулгах ажлыг Европ зураачийн гарт атгуулахыг зүрхлээгүй би харин наранд хандсан юм. Гэрэлд мэдрэмтгий цаасыг хөшөөний бичээсийн харалдаа байрлуулсан камер-обескурт хийж, Дагерр ба Тальбертын аргаар нарны туяа бичээсийг жижигрүүлэн камер-обескурын хайрцгийн ёроолд тусгав. Ингээд мэдрэмтгий цаасан дээр буулгаж бэхжүүлсэн зургийг ердийн аргаар барлан гаргав. Энэ явцад санаатай хийгээд санаандгүй алдаа гарна гэж үгүй. Найм дахин томруулдаг шилийг гартаа аваад харвал нүдний тань өмнө бичээс бодит хэмжээгээрээ харагдах болно¹⁰.

П.С.Савельев

⁹ *Сибирский вестник*, 1, с., зураг XXII.

¹⁰ *Memoires*, etc. 1. с.

ЧИНГИС ХААНЫ АЧ ДҮҮ ЕСҮНГЭ ВАНГИЙН ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ МОНГОЛ БИЧЭЭСИЙН ТАЙЛБАР

Дорж Банзаров

Академич Шмидт агсан энэхүү бичээсийн орчуулгыг “Шинжлэх Ухааны Академийн эрдэм шинжилгээний бичиг”-т хэвлүүлэхдээ орчуулгынхаа хэл бичгийн дүгнэлт хийгээд дурсгалын түүхийн талаарх тайлбарыг дорвитой хийгээгүй байна. Тэрбээр дурсгалын талаар их л эерэгээр тэмдэглэж “чулуунд гарсан ан цав бичээст ямар ч хохирол учруулаагүй”, тиймээс бичээсийг “ихэд хялбархан” тайлж уншсан бөгөөд өгүүллийнхээ ард хавсаргасан хөшөөний хуулбар зургийг “үнэн зөв” хэмээн тэмдэглэжээ. Тухайн үед н. Шмидтийн судалгааг мөшгөн шинжлэхийг хэн ч зүрхлээгүй төдийгүй академичийн зүгээс ийнхүү эрс шийдэмгий батлан хэлсний дараагаар хянан нягтлах нь ч илүүц байв.

Миний бие гэрэлт хөшөөг бүхэлд нь багтаасан илүү тодорхой зургийг 1848 онд буулган авч, бичээсийг нь анхааралтай шинжилсний дүнд н. Шмидтийн үйлдсэн хуулбар зураг төдийлөн зөв бус болохыг, мөн түүний хийсэн орчуулгыг засаж залруулах шаардлагатай гэдгийг ойлгосон билээ. Бичээсийг шинээр уншиж, тайлбарлахдаа миний бие огт зоргоор авирлаагүй бөгөөд өнөөгийн монголчуудад үл ойлгогдох боловч XIII зуунд хэрэглэж байсан гэмээр үгсийг тодорхойллоо. Харин н. Шмидт энэ тохиолдолд хэтэрхий дур зоргоор авирлан бичээсийг орчин цагийн үгээр хэлбэл “ихэд хялбархан тайлбарласан” байна. Гагцхүү энд л бичээсийг тайлж унших миний аргын ялгаа оршиж байгаа юм. Чухам хэнийх нь зөв болохыг үр дүн л харуулна. Юуны өмнө уншихад төвөгтэй үгсийг тайлбарлаад дараа нь бичээсийн бүрэн орчуулгыг толилуулъя.

I

Сартагул хэмээх үгийг н. Шмидт Sartaghol хэмээн уншаад Хар Хятадын хант улсын монгол нэр гэжээ. Хар Хятадыг монголчууд *сартагул* гэж хэзээ ч нэрийдэж байгаагүй, зөвхөн Хивийн оршин суугчдыг ийнхүү нэрлэх бөгөөд энэ үгийг *Сарт* гэсэн үгээс гаралтай гэх агаад Хива болон Бухарын хүн амыг бүрдүүлэгч түрэг угсааны перс гаралтай нутгийн уугуул иргэдийг нэрлэдэг¹.

Түрэг аймгийн *Сарт* хэмээх үгэнд монголчууд *гур* (төр улс) гэсэн үг залгаад *Сартагур* гэхийн оронд *Сартагул* гэж дуудах болсон нь тэд нэг үгэнд орсон хоёр *p* үсгийн ард эгшиг ороогүй л бол хоёр *p* үсэг хэлэхэд хэцүү агаад сүүлийн *p* нь гол төлөв *л* болон хувирдагтай холбоотой юм (Үз: Бобровников. *Грамматика монгольско-калмыцкого языка*, стр.32).

Чингис хааны үед Хива нь Бухар, Хива болон Персийн хэсгийг хамарсан асар том Хорезмын эзэнт гүрний нийслэл хот байв. Хорезмын шахын захиргаанд байсан энэхүү эзэнт гүрнийг монголчууд *Сартагул* хэмээн нэрийдэж байлаа. Зургаан жилийн аян дайнаар (1219-1225) түүнийг эзлэн авсан нь Чингис хааны түүхийн нэгэн чухал үйл явдал байсан бол Хар Хятадыг эрхшээлдээ оруулсан нь төдийлөн анзаарагдаагүй үлджээ. Чингис хааны дайлсан Найманы эзэн Хүчлүг хан XIII зууны эхээр Хар Хятадын хууль ёсны ханыг зайлуулан тус улсын хан ширээг гартаа авч дөнгөсөн байна. Чингис хаан Хива руу дайлаар мордохынхоо өмнө ар талаа аюулгүй болгох үүднээс Орос руу 1224 онд хийсэн довтолгооноор алдаршсан Зэв ноёныг 20 мянган цэрэгтэй 1218 онд хөдөлгөв. Хүчлүг хан монголчууд айсууг дуулаад баруун тийш зугтахад түүний хөсөр хаясан улс нь монголчуудад эсэргүүцэлгүй бууж өгчээ. Зэв ноён Хүчлүгийг мөшгөн Бедехшаны ууланд барьж авч хөнөөгөөд мөн 1218 ондоо нутаг

¹ Үз: Meyendorff. Voyage d'Orenbourg à Bokhara; Н.Ханыкова. Описание Бухарского ханства.

буцжээ². Чингис хааны огт оролцоогүй уг хялбар байлдан дагуулалтыг Шмидт “агуу бөгөөд шийдвэрлэх” үйл явдал байсан гээд Чингис хаан түүнийг чухалчлан 1219 онд эсвэл 1220 онд бидний үзэж буй дурсгалыг босгосон гэж үзсэн байна.

н. Шмидтийн ийнхүү ташаарах болсон нь нэгдүгээрт, бичээсийг буруу уншсантай холбоотой, хоёрдугаарт, Саган Сэцэний түүхийг хэвлүүлэхдээ эх бичгийг шүүн нягтлаагүйтэй холбоотой юм. Энэхүү түүхийн зохиогчийн он дараалал хятад болон мусульман түүхчдийнхтэй огт нийцэхгүй буйг эх бичигт ташаа зүйл байгаа хийгээд Монголын он тооллын арга өвөрмөц байдагтай холбож үзвэл зохино. Монголчууд жилийг 12 амьтны нэрээр тоолохдоо дээр нь 10 болзолт тэмдэг нэмнэ. Улмаар энэ хоёрын нийлбэрээр 60 жилийн мөчлөг бүрдэнэ. Нэг мөчлөг дуусахад шинэ мөчлөг мөн жилийн дарааллаар эхэлнэ. Он тооллын энэ аргаар нэг болзолт тэмдэгийн оронд тухайн жилийн амьтны нэрийн дэргэд өөр болзолт тэмдэг тавьж андуурах явдал гарч болох агаад (гар бичмэлд тохиолддог) ингэснээр тухайн жил огт өөр жил болон хувирна. Иймэрхүү буруу зүйлийг залруулж болох ба гол нь тухайн жилийн амьтны оронд өөр амьтныг тавихгүй байх нь чухал. Тухайлбал, Саган Сэцэнд тэмдэглэсэн ёсоор *Сартагул*-уудыг Чингис хаан *и туулай* жил буюу 1195 онд эзэлжээ. Гэтэл бусад багтай эх сурвалжийн мэдээгээр тэрбээр Хива руу 1219 онд довтолсон билээ. Хэрэв *и туулай* жилийн оронд *ки туулай* гээд бичвэл 1219 он болох жишээтэй. Хорезмын шахын эсрэг дайны үйл ажиллагаа эхэлснээр түүний эзэнт гүрэн эзлэгдсэн гэж монголчууд үздэг байна. Иймд Саган Сэцэн тухайн улсын нэр болон он цаг дээр алдаагүй гэсэн үг юм. Мөн түүний хэлж буйгаар *Тукмак*³-уудыг *бин луу жил* (эрэгчин улаан луу) буюу 1196 онд эзлэн авсан гэдэг нь үнэнд үл нийцнэ. Хэрэв *бин* тэмдгийн оронд *у* тэмдэг тавибал *у луу жил* (эрэгчин шар луу) жил буюу 1208 он болно. Үнэндээ Хүчлүг хан тукмакуудыг эзлэн авсныхаа дараа 1208 онд Чингис хаанд бут цохигдсон байдаг. Энд Тукмакуудын хан болсон Найманы хан бут цохигдсон гэснийг Саган Сэцэн тукмакууд эзлэгдлээ гэж үзсэн байна. Хэрэв н. Шмидт иймэрхүү аргаар он цагийг зассан бол өөрийнхөө алдааг мөн залруулж, *сартагул* болон *тукмакууд* нарын эздийн нэрийг солих тухай саналыг тайлбартаа тусгаж мунгинахгүй байсан билээ⁴.

II

Шмидт эзэлэжү ‘овладев’ гэж дур зоргоор уншсан байна. Энэ үгэнд *з*, *лэ* гэсэн үеүд огт байхгүй. Харин энэ үгийг *аулижү* гэж тайлж унших хэрэгтэй. Монголчуудад иймэрхүү үг үгүй боловч чулууны ан цав тус үгийн эхэнд таарсан тул үгийн эхний *т* үсэг гээгдсэн гэж үзүүштэй. Энд *таулижү* буюу “дайлах, дайлсны дараа” гэсэн үг байсан байна.

таулиху хэмээх үйл үгийг *тагулиху*, *тэгулиху* (цагадай хэл: *тугульмек* “доошоо унах, босон харайх”) хэмээн бичих агаад *дээрээс таишуу доошоо чиглэсэн үйл хөдөлгөөнийг* заах тул махчин шувуу *ангаа шүүрэх*, зэрлэг адуу *харайлах*, уулгалах, *давхих*, *харайн дайрах*, *мөргөх*, цэрэг дайны үйл хэрэгт *довтлох* гэсэн утга илэрхийлнэ.

III

Шмидт *эртэнү* ‘древный’ гэж тайлан уншиж байна. Эртний бичээс судлалын үүднээс үзвэл *арат-и* эсвэл *эрэти* гэж унших ёстой. *арати* гэдэг нь “хүмүүс” гэсэн утгатай бөгөөд ингэж унших нь бичээсийн утга санаанд илүү тохирно.

Энэ үгэнд орсон *и* үсгийн өмнө шилбэ сунасан байгаа нь *р* үсгийн өмнө ба түүний ард *а* эгшиг (*ара*) буйг заах зорилготой юм.

² D’ Ohsson. *Histoire des Mongols*. T. I, p.163-176.

³ Тукмак гэдэг үгийн талаар дараах бүтээлд үзнэ үү: Charmoy. *Expedition de Timour*, p.170, 245.

⁴ Үз: Иакинф. *История четырех ханов*, стр.40.

IV

Шмидт *бога оргай хориксан* (bogha orghai choriksan) хэмээн уншиж bogha orghai гэдгийг хаанаас авсан гэдгээ заалгүй “туйлын үзэн ядах” хэмээн орчуулсан ба энэ нь монголчуудад огт ойлгомжгүй юм.

Ванчиковын хийсэн орчуулгын хариу болгон тэрбээр бичихдээ халимагт *орга* гэсэн үг “туйлын, төгс” гэсэн утгатай гэж батлан өгүүлжээ. Үнэхээр халимагуудад *ороуга* “ор үгүй” гэсэн хэллэг байх агаад *орга* гэж хэлдэг. Гэхдээ үгүйсгэсэн тохиолдолд “туйлын, төгс” гэсэн утга илэрхийлнэ. Магадгүй Шмидт энэ хэллэгийг эш татсан байх. Гэвч манай бичээсийн агуулгын утгад нийцэхгүй байна.

хориксан гэснийг н. Шмидт “саад тавих, төгсгөл” хэмээн орчуулсан боловч энэ үг “шивээлэх, түгжих, хориглох” гэсэн утгатай. Эл үгийн эхний хоёр утга нь Шмидтийн “туйлын үзэн ядах” гэсэнтэй авцалдахгүй байгаа бөгөөд сүүлийн “хориглох” гэсэн утга нь бүр ч тохирохгүй. Учир нь монгол хүн “үзэн ядацгаа! гээд хориглов” гэнэ. “Үзэн ядах хориглов” гэсэн орос хэллэг монгол хэлний утга санаанд огт нийцэхгүй.

Энэхүү гурван үгийг *Буга Сучигай хуриксан* (*Сучигай* гэсэн үгийн эхэнд буй *с* үсгийг ан цав дайрсан) гэж уншвал зохимжтой. Эхний хоёр үг бол газар усны оноосон нэр, харин *хуриксан* гэдэг үг “хурах, цугларах” гэсэн утга илэрхийлсэн эдүгээ хэрэглэгддэггүй боловч *хуримой* (цагадай хэлний *курамак*) хэмээх тодорхой үйл үгийн үүсмэл үгээс үүсэлтэй өнгөрсөн цагийн үйлт нэр юм. Энэ үгээс үүдэлтэй үгүүд: *хурим, хурилдай, хураамуй*.

Хорезмын эзэнт гүрнийг сүйтгэсний дараагаар Чингис хаан нутаг буцах замдаа 1224 оны зун, өвөл Эрчисийн чиглэлд аян дайн хийж өнгөрөөжээ. Bouca Soutchicu (Буга-Сучику; манай бичээст *Буга Сучигай*) хэмээх газар цэрэг дайчиддаа зориулан “хурим” найр хийсэн бөгөөд 1225 оны 2 дугаар сард эх нутагтаа ирсэн гэж Д’Оссон “Монголчуудын түүх” номдоо тэмдэглэсэн байна⁵. Манай бичээст монголчууд энд хурилдай явуулж, түүнийг хэзээд дагалдаж ирсэн “хурим” найр хийсэн хэмээн Д’Оссоноос илүү тодорхой өгүүлсэн байна.

Чингис хаан, арат гэсэн үгийг *хуриксан* хэмээн үйлт нэрийн өгүүлэгдэхүүний хувьд латин хэлний тодорхойгүй заахын тийн ялгалтай төстэй монгол хэлэнд одоо мөрдөж буй дүрмээр заахын тийн ялгалд тавьсан байна (Үз: Бобровников. *Грамматика монгольско-калмыцкого языка*. §477). *Буга Сучигай* хэмээх үгийг орны тийн ялгалын нөхцөлгүй бичсэнийг *хуриксан* гэсэн үйл үгийн өмнө байрлаж түүнтэй холбоотой болох нь илэрхий байгаагаар тайлбарлана.

Персийн түүхч Мирхондын тэмдэглэснээр Чингис хаан Хорезмын эсрэг аян дайнаас буцаж ирээд Кулан Язы⁶ хэмээх газар хурилдай хийжээ. Энэ хоёр түрэг үг “Хулангийн (зэрлэг илжиг) тал” гэсэн утгатай. Бидний Буга Сучигай буюу Сучику хэмээх нь монголоор “буга цочих” буюу “буга үргэдэг газар” гэсэн утгатай. Эдгээр газар усны нэрийн утгад байгаа зарим нэгэн төстэй зүйл нь хоёр ард түмэнд нэг газрыг ижил утгатай нэрээр нэрийдэж байсан хэмээн үзэж болохоор байна. Мирхондын тэмдэглэсэн хурилдай бол манай бичээс болон д’Оссоны бүтээлд дурдагдсан тэр л хурилдай байх ёстой. Буга Сучигай хэмээх газрын тухай түүхэнд мэдэгдэж буй зүйл үгүй, харин Кулан Язы гэдэг талын тухайд гэвэл энд 1199 онд Хэрэйдийн Он ханы Наймантай хийсэн тулаан болсон ажээ⁷. Энэ тулалдаан нь Он ханы

⁵ *Geschichte der Ost-Mongolen*. S.87.

⁶ *Histoire des Mongols*. T-I. 1834, p.325.

⁷ И.Н.Березин профессор Мирхондын энэ хэсгийг орчуулж надад сонордуулахдаа: “Өвөл шувтарч, айсуй хавар хээр тал цэцэгсээр хучигдахад Чингис хаан цэрэглэн Самаркандаас хөдлөхдөө султан Мухаммедын эхийг түүний эхнэрүүдийн хамт цэргийн өмнө орж, Султан болон түүний титэм, сэнтий хийгээд ноёд түшмэлүүдийн хойноос гашуудан орь дуу тавьж явахыг зарлигджээ... Сейхун мөрний эрэг дээр Цагадай, Өгөөдэй хоёр дэлхийгээр бядагч Ордтой ирж нийлээд Сейхун мөрнийг гатлаад Хулан Язы-д хүрэв. Зүчи Дешти-Кыпчакийн талаас бүслэн хаав. Нөгөө талаас нь Чингис хаан хөвүүд ноёдын хамт хоморголов. Хэсэг хугацааны дараа авлагчид ан авлагын газарт нэгдсэнээр бүслэлтийн тойрог нийлэв. Чингис хаан мориндоо мордож голд нь хүрч очоод олон тооны

довтолсон Найманы нутагт болсон байх ёстой. Иймээс Кулан Язы эсвэл Буга Сучигай хэмээх газар нь Найманы нүүдэллэж байсан Алтай нуруу болон Дээд Эрчис мөрний ойролцоо оршиж байх ёстой. Уг газар нь Чингис хааны Хорезмын эзэнт гүрнийг дайлаар мордохдоо хийгээд уг аян дайнаас буцахдаа дайран өнгөрсөн тэр л газар юм. Энэ нутагт үнэхээр хулан болоод буга байдаг.

V

Есүнгэ. Эл үгийг эрхэм зүйлийн нэр эс бөгөөс эзэн хүний нэр мэт мөрийн дээр байрлуулсан байгаа ба монгол хэлний энэ дүрмийг мэдэх атал Шмидт түүнийг *ирункэ* “ер нь” гэж уншжээ. Хэрвээ тийм бол уг үг бичээс дотор хүндтэй догол мөрөөс эхлэх ёсгүй юм. Энд Чингис хааны үеэлүүдийн нэгийн нэр *Есүнгэ* гэж маш тодорхой харагдаж байна. Энэ хүн бол манай бичээсийн гол хүн, тиймээс түүний талаар бид доор тодорхой ярилцах болно.

VI

Шмидт Ononodurun, Chondodurun, Chondojourun хэмээн тайлж унших санал гаргасан. Миний бодлоор энэ үгийг Онтодор, Ондодор, Онхотор, Хонходор эсвэл Хонгодор хэмээн уншиж болох юм. Бичээсийн утга агуулгаар тус үг нь Есүнгэ вангийн хувь газар нутгийн багавтар монгол отгийн оноосон нэр болох нь гарцаагүй. Монголчуудын дунд эдүгээ хүртэл Хонгодор овог оршиж байгаа бөгөөд Аларын захиргааны (Эрхүүгийн тойрогт) бараг бүх буриадууд Хонгодор аймагт харьяалагдана. Тэд жинхэнэ буриадууд бус харин Сибирь лүү XVII зуунд нүүж очсон монголчууд тул урьд өмнө нь Аргуны нутгаар нүүдэллэж байгаад Есүнгэгийн хувь болон очсон эдгээр хонгодоруудын тухай бичээст дурдсан байна гэж таамаглах бүрэн боломжтой юм. Чингисийнхний самууны үед тэд бэлчээр нутгаа ойр ойрхон сэлгэж шинэ эздэд харьяалагдаж явсан байж болно. Энэхүү багавтар отгийн талаар түүхэнд тэмдэглэгдээгүй байгаа нь төдийлөн чухал бус байсантай холбоотой байж магад.

Цаг хугацааны явцад энэ үгийн x $\rightarrow$ үсэг m $\rightarrow$ болон хувиртлаа хамгийн их өөрчлөгджээ.

VII

Бичээсийн сүүлийн хоёр үгийг орчин цагийн монгол хэлээр тайлбарлах боломжгүй юм. Шмидт эртний дурсгалд одоогийн мартагдсан үг тааралдаж болохгүй мэт аашлан орчуулгаа баллан байж ингэж хийсэн байна. Тиймээс би тэдгээр үгийг монгол хэлэнд одоо үл мэдэх боловч байж болох үгээр монгол хэл болон түүнтэй төрөл манж, түрэг хэлэнд дээд зэргээр тохирох хэл бичгийн ухааны шинжлэлийн тусламжтайгаар тайлбарлая. Эдгээр хэлэнд утгвар үг байхгүй тул үгийн язгуурын араас янз бүрийн дагавар залгах аргаар үг бүтээдэг. Үүний улмаас үг тус бүрийн эхний үе үгийн язгуур байх агаад ихэнхдээ нэг үетэй байна. Хэрэв үг олон үетэй бол үгийн язгуурын араас үүсмэл үгийн толь зүйн утгыг бүрдүүлсэн нэг буюу хоёр дагавар шууд залгагдана. Тиймээс бүх эгшиг, гийгүүлэгчийн янз бүрийн холбоосын тусламжтайгаар гаргаж авах үеийн тоо хэд байна төдийгөөс илүүгүй үгийн язгуур эдгээр хэлэнд байж болно. Үгийн баялаг арвин байх их итгэл төрүүлэхгүй ийм аргаар Дундад Азийн хэл бүрэлдэхэд нэг үетэй үгийн язгуурын тодорхойлох шинж нь үүсмэл үгэнд хэзээ ч гээгдэхгүй тохиолдолд энэ итгэл улам буурч байгаа юм. Энэ утгаар мэдрэхүйн эрхтнээр мэдрэх эсвэл эд зүйлийн хөдөлгөөн буюу байрлал (харах эрхтэн) эсвэл авиа дуурайх (сонсох,

ан эхлүүлэв. Хан хөвүүд, ван ноёд ан авлага хийж дууссаны хойно бусад амьтныг өөрийн тамгаар тамгалж суллаав. Зүчи эцэгтэй ирж сөгдөж мөргөн гарыг нь үнэсэх ёслол үйлдээд дүү нараа тэврэн мэнд мэдэлцсэн ба хаанд барьсан олон тооны бэлгээс зуун мянган морьдын дотор хорин мянга нь дан орог зүсмийн байв. Бүгд тэр газартаа зусав. Тухайн газарт хол ойроос ирсэн ноёд хуран цугларахад хуралдай хийж, хэсэг уйгур ноёдыг цаазаар аваачив” гэжээ (*Vie de Djenghiz-khan*, par Mirkhond, 168-169).

үнэрлэх, мэдрэх) маягаар хүний мэдрэлд нөлөөлөх хөдөлгөөний үед хүний гаргах авиаг илэрхийлдэг байна. Үүсмэл үг дэх энэхүү цэвэр эд материалын төсөөлөл нь жиших аргаар цэвэр амархан оюун ухааны ойлголт болон хувирдаг байна. Үгийн нэг язгуураас магадгүй хоорондоо ямар ч нийтлэг утга агуулаагүй үг үүсдэг байна.

Тухайлбал, дээшээ хөдөлгөөнийг заасан *бул*- гэсэн язгуураас үүссэн *бул-ги* “харайх”, *бул-тай* “бултайх”, *бул-ак* “булаг” (газар доороос дээш оргилох), *бул-чин* “хөлийн булчин”, *бул-дак* “болдог, толгой”, *бул-га* “бослого, үймээн”.

Язгуур болон дагаврын утгыг мэдэх хэн хүнгүй үгийн энэ хэсгүүдийг тогтоогоод тухайн үгийн утгыг ойролцоогоор хэзээд тодорхойлж чадах билээ. Шаардлагатай үгүүдээ бид энэ аргаар тайлбарлана.

Бичээсийн гурав дахь мөрийн сүүлчийн үгийг *элие* (Elije) “адын тэнгэр” хэмээн Шмидт зоргоороо уншсан байна. Бидний хавсаргасан зурагт *алдак* эсвэл *алтак* гэж уншигдаж байна. Би бээр “суман, хороо” гэсэн утгатай *ал* хэмээх үгээс гаралтай “дайчин, цэрэг” гэсэн утгаар энэ үгийг сонгож байна.

Энэ үгийн *л* болон *т* үсгийн хооронд эгшиг аваагүй гэдгийг харуулахын тулд нийлүүлэн бичжээ. *ал* хэмээх үг “хороо” гэсэн утгаар Сеадет-Гирейн дархалсан зарлигт тохиолддог⁸. *Алым, кушуным, мингим, туманым тиб* гэх мэтээр “миний суман, миний хороо, миний мянган, миний түмэн (арван мянга)-ээс (гувчуур) нэхэхгүй” гэж тэнд дурджээ.

Монголчууд цэргээ аравт, зуут, мянгат, түмт гэж хувааж байсныг бид мэднэ. Түүнээс гадна хошуу, сум буюу түүнээс дээш нэгдэл байсан байна⁹. Монголчуудын өнөөгийн зохион байгуулалтаар хошуу гэдэг нь цэргийн хувьд суман, заланд хуваагдсан дивизийг бүрдүүлсэн том бус хувь нутгийг хэлнэ. Энэ зохион байгуулалтыг манж нар нэвтрүүлсэн бөгөөд түүнээс өмнө монголчууд Чингис хааны зохион байгуулалттай байв. Дээр дурдсан зарлигт гарч буй цэргийн хуваарийг багаас том руу өсөх хандлагаар нэрлэсэн бөгөөд *ал* нь одоогийн залан буюу сумангийн нэг төрөл *хошуунаас* (түрэг хэлэнд үлдсэн *алай* “суман”) бага байсан гэж үзүүштэй. Зуут, мянгат гэсэн хуваарь бол цэвэр цэргийнх байсан бол *ал*, *хошууны* хуваарийн эх үүсвэр нь овгийн эрх буюу өв залгамжлалаа хуваах эсвэл өв залгамжлагчдын дунд отог хуваах явдал байв. Иймээс *ал*-ийг “анги, хэсэг” гэж орчуулж болох агаад *ал-так* (*ур-так* “шадар”-тай харьцуулж үз) гэдэг нь “аль-д харьяалагдах” тодорхой нэг ангийн энгийн цэрэг дайчин гэсэн утгатай. *Аль* гэсэн үгийн язгуур үнэн хэрэгтээ орос хэлнээ *раз*- угтвар үгээр илэрхийлэх утга агуулах буюу *распространение* “дэлгэрүүлэх”, *раздвигание* “ангайлгах, алцайлгах”, *разделение* “хуваарилах”, *расширение* “өргөтгөх”, *разъяснение* “тайлбарлах” гэх мэт. Уг язгуураас үүсэлтэй *алхумой* “алхах” буюу “хөлөө алцайлгах”, *алхимой* “зодолдох, ноцолдох” буюу “гараар далайх, цохих”, *алжиямой* “ядрах” буюу расстроиться (бүтэлгүй болох), быть разбиту (бут цохигдох), *алцаймой* “хөлөө алцайлгах”, *алус* “дамжуулан”, *алда* “алд” буюу “хоёр гарыг хөндлөн сунгасан урт”, *алман* “өргөн”, *алмай* “ухаан муутай, ухаан муудсан”, *алан* “алаг” буюу “сарниун өнгөтэй”, *алиа* “томоогүй”, *албин* “ад чөтгөр, хээрийн гал”, *алдар* “нэр алдар” буюу “дэлгэрэх нэгэн зүйл” г.м.

VIII

Бичээсийн төгсгөлийн үгийг Шмидт *шиндарулга* “үлдэн хөөх” гэж орчуулсан байна. *шиндарулга* хэмээх үг хэзээ ч ийм утгатай байгаагүй тухай яриад ч хэрэггүй бөгөөд бичээст энэ үг огт байхгүй юм. Цаг хугацааны нөлөөнд ихээхэн эвдэрсэн төгсгөлийн үгийн эхлэлийг *онд* эсвэл *унд* гэж уншиж болохоор байна. Дараа нь тодорхойгүй хэдэн зураас яваад эцэст нь *лага* гэсэн нь тодорхой байна. Монгол үгийн бүтцээр үзвэл энд нэр үг *шиндарулга* бус үйл үг байх ёстой. Ер нь монгол хэлэнд өгүүлбэрийг нэр үгээр төгсгөдөггүй. Энд *ондулага* “хувь авав” гэдэг

⁸ Үз: Ярлыки Тохтамыша и Сеадет-Гирея, стр.4.

⁹ Charnoy. Expedition de Timour, p.208, 253, 391; Journ. Asiat., 1836, septembre, p.224.

үг бичээстэй байна хэмээн үзвэл хөшөөний бичээсийн утгад хамгийн их тохирч байгаа болно.

Үүсмэл үгээс харахад *он* гэсэн язгуур эсрэг тэсрэг, онцлог, саланги, хуваалт гэсэн утгыг илэрхийлж байна. Түүнээс дараах үгүүд ч гарсан байна. Үүнд манж үгс: *он* “зай”. Тухайлбал, нэг өртөөнөөс нөгөө өртөө хүртэл – *ондомби*, “хийвэл зохих зүйлээс эсрэг юм хийх, эвдрэх, бүтэлгүй болгох” (түрэгээр *онмак* “харах, хагарал гаргах”), *ончо*, “өргөн, дэлгэр”, “ангайлгасан” гэж хэлмээр. Монгол үгс: *онь* “сумын чих”, “хавцал” (хуваагдсан зүйл), *ондо* “ондоо, өөр”, *онцо* “цорын ганц, ганц, онцгой”, *онхойн* “дүнсгэр, ярианд оролцохгүй тусдаа суух”. *Он* гэсэн язгуураас *ондомой* гэсэн салгах, тусгаарлах гэсэн утга агуулсан үйл үг бүтэх нь зүйтэй байж мэднэ. Тус үйл үгэнд учир шалтгааны хэлбэрийг (*causalis*) нэмбэл үйл үгийн үйлдэгдэх хэвийн оронд хэрэглэгддэг *ондуламой* болно. Ийнхүү *ондулага* (-га өнгөрсөн цагийг заах нөхцөл) гэсэн үг “тусгаарлагдсан” гэсэн утгыг заана. Тэр тусам бичээст өв хөрөнгө хуваасан тухай өгүүлж байгаа билээ. Тодорхой болгох үүднээс би түүнийг “хувь болгон авав” гэж шууд орчуулсан болно. *Ондомой* хэмээх үйл үг үнэхээр байсныг эдүгээ монгол хэлэнд байгаа *ондомой* хэмээх “цухуйх, ёрдойх, хүрээлэн буй эд зүйлээс эрс ялгарах” гэсэн утга бүхий үйл үг нотолж байгаа юм. *Ондомой* хэмээх үгээс үүдэлтэй энэ үгийн хэлбэрийг эд зүйлийн гаднах байрлалыг заасан *й* залгаж *бултаймой* гэсэн үгийг *бултамой*, *хазаймой* гэсэн үгийг *хазгар* гэсэн үгээс бүтээсэн шиг зөв үүсгэсэн байна.

Ондогоулик “хурц үзүүртэй, конус хэлбэртэй, товойн гарсан, салан тусгаарласан” хэмээх утгатай үг бас бий.

Бидний үзэж буйгаар хөшөөний бичээсийг дараах байдлаар уншиж болно. Үүнд:

- 1) *Чингис-хан-и*
- 2) *Сартагул иргэн таулижу багужу хамук монгол улусун*
- 3) *арат-и Буга-Сучигай хуриксан-дур*
- 4) *Есүнгэ Хонгодор-ун гурбан загун гучин табун алтак*
- 5) *тур ондулага*

Энэ нь:

Чингис хаан сартуулын хот руу довтолсны дараа буцах замд Монголын бүх овгийн хүмүүс Буга Сучигайд цугларахад Есүнгэ Хонгодорын гурван зуун гучин таван цэргийг хувь болгон авав

гэсэн утгатай ажээ.

Бичээсийн утга маш энгийн байна. Чингис хааны ач дүү Есүнгэ авга ахаасаа өв залгамжлах эрхтэйгээр том бус хэсэг цэрэг авч энэ хишиг хийгээд өөрийн эрх мэдлээ мөнхжүүлэх үүднээс эдүгээг хүрч ирсэн гэрэлт хөшөө босгожээ. Бидний тайлж уншсан ёсоор бичээст өгүүлсэн зүйлийг түүх бүрнээ нотолж байна. Чингис хаан 1224 оноос өмнө өөрийн хөвүүд болон төрөл төрөгсөддөө хувь хуваах боломжгүй байв. Тэрбээр Монголын нүүдэлчин аймгуудтай 1210 он хүртэл тэмцэл хийж байгаад 1210-2018 оны хооронд Хятадтай дайтаж, эцэст нь 1219-1224 онд баруун тийш аян дайнд мордсон байдаг. Чингис хаан Перс рүү (манай бичээст Сартуул руу) хийсэн аян дайнаас буцахдаа үр хүүхэддээ газар нутаг оноож өгөв хэмээн Гаммер “Алтан ордны түүх” хэмээх бүтээлдээ тэмдэглэсэн байна¹⁰. Энэхүү хуваарилалтаар манай бичээст буй Есүнгэ Чингис хааны ойр төрлийн хүний хувьд хувь хүртэх учиртай билээ. Тэрбээр байлдан дагуулагчийн төрсөн дүү Зоч Хасарын хүү юм. Перс хэлээр бичигдсэн “Монголчуудын түүх”-ийн алдарт зохиогч Рашид-ад-Диний тэмдэглэснээр Зоч Хасар “дөчин хөвүүнтэй байснаас нэрд гарсан нь зөвхөн гурав юм. Бигу, Тугу ба Исунку (манай бичээсний Есүнгэ)”¹¹. Рашид-ад-Диний “нэрд гарсан” гэдгийг тайлбарлавал Зоч Хасарын олон хөвүүнээс энэ гурав нь түүний авааль хатнаас төрсөн тул хан хөвүүдийн эрх

¹⁰ *Gesch. der Goldenen Horde*, 89-90.

¹¹ Эрдман. *Предки Чингис-хана*. Журн. Мин. народн. просв., Т-XXXVIII, 1843, отд. 1, стр.104.

мэдэл буюу хувь хүртэх, хурилдай буюу улсын их хуралд оролцох болон их хааныг сонгоход оролцох эрх бүхий ажээ. Үнэхээр Бигу, Тугу болон Есүнгэ нар 1251 онд Мөнх хааныг хаан ширээнд өргөмжлөх хурилдайд оролцсон байна¹². Персийн түүхчийн бичсэнээр “Есүнгэ өндөр нуруутай, урт сахалтай, ...төрийн хэрэгт гарамгай тул олны хүндэтгэл хүлээж байв... Чингис хаан өөрийн хөвүүддээ цэрэг хувааж өгөхдөө Зоч Хасарын хөвүүд буюу Бигу, Тугу, Есүнгэ нарт холимог цэргээс тус тусд нь зуу зуун хүн олгов”. Рашид-ад-Диний эдгээр хороонууд нь мөн чанартаа монголчуудын *ал* хэмээн нэрлэж байсан зүйл бөгөөд бидний бичээст Есүнгэгийн “хороог” бүрдүүлж байсан хүмүүсийг *алтак* гэсэн байх магадлалтай. Зоч Хасарын хөвүүдийн гурван “хороо” (эсвэл *ал*) их хаант улсын тус тусдаа нэгжгээд арми болж, Рашид-ад-Диний түүхийнхээ өөр хэсэгт өгүүлсэн ёсоор мянган цэргээс бүрдэх нэг “батальоныг” бүрдүүлж байв¹³. Энэхүү батальон буюу монгол хуваариар нэг гэр бүлийн вангийн хувь гэсэн утгаар оногдсон *мянган* нэг *хошууныг* бүрдүүлж байсан бололтой. Хэрэв мянгыг ах дүү гурвын дунд хуваах аваас Есүнгэгийн хувьд бичээст заасан тооны хүмүүс буюу гурван зуун гучин гурав оногдож байгаа юм.

“Зоч Хасарын овог ба Есүнгэгийн орд өргөө, нутагладаг бууц нь Монголын дотор зүүн хойд Эргүнэ (Аргун) мөрөн, Хөл нуур (Хөлөн буюу Далай нуур), Хайлаар нутгаар (энэ нуурт зүүн талаас нь цутгадаг гол) байв”. Дурсгал байсан газраас арай доор Аргун голоос холгүй Хархираа голын эрэг дээр туурь нь байгаа орд өргөөний дэргэд Есүнгэ вангийн босгосон манай хөшөө олдсон билээ¹⁴.

Ийнхүү түүх бидний тайлж уншсныг зөвтгөж байгаа тул н. Шмидтийн тайлбарын эсрэг цааш ямарваа зүйл хийхийг илүүц болгож байгаа юм. Түүхийн хувьд манай бичээс нь монгол бичгийн хамгийн эртний дурсгал болох агаад Ази, Европын түүхэн үйл явдлыг илэрхийлсэн тул гайхамшигтай юм. Чингис хаан хурилдай дээр өөрийн үр хүүхэддээ хаант улсыг хуваан өгснөөр Орос болон бусад олон улс орны хувь заяаг шийдсэн байна. Чингис хааны хүү Зүчи ханд хараахан эзлэгдээгүй боловч Зэв, Сүбэдэй нарын Каспийн тэнгисийн орчмын орнууд болон тэдний хөрш залгаа Орос орныг эзлэх боломжийг судлах зорилгоор 1224 онд Кавказын нурууг даван хийсэн тагнан мэдэх довтолгоогоор шийдвэрлэсэн Кипчакийн нутаг оногдов. Дурсгалыг бүтээсэн цаг хугацааг Есүнгэ Хархираа голын эрэг дээр ордондоо насан өөд болохоос өмнө 1224 оноос 1300 оны хооронд барьсан үетэй холбон үзэх нь зүйтэй юм.

* * *

¹² Иакинф. *История четырех ханов*, стр.306; зөвхөн энэ бүтээлд Егү болон Тугу гэдгийг Екэ-Тоган (Их тогоо) гэж нэг хүний нэр болгосон буй.

¹³ Эрдман. *Предки Чингис-хана*. Журн. Мин. народн. просв., Т-XLIV, 1844, отд. 1, стр.85. Рашид-Аддины бүтээлийг орчуулагчид, мөн н. Эрдман эх бичигт буй нэр томъёог одоогийн орос хэлний үгээр буулгажээ. Иймд *полк* “хороо”, *батальон* “батальон” гэж орчуулсан нэр томъёонууд нь угтаа ямар үгс байсныг мэдэх нь сонирхолтой юм. Магадгүй Рашид-Адин уугуул монгол үгээр тэмдэглэсэн байх.

¹⁴ Энэхүү гэрэлт хөшөөний зургийг н. Спасский хэвлүүлсэн болно. Энэ өгүүллийн өмнөх үгийг үзнэ үү. .

X.

ॐ नमो भगवते वासुदेवाय

Handwritten text: *Handwritten text, possibly a signature or name, written vertically.*

for "opening" doors.

The way back is down - Winton

Do not